

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Засгийн газрын 2021 оны "Журам батлах эрх олгох тухай" 381 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ын 2.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/2.1 дэх хэсэгт:

"2.1.Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д заасны дагуу холбогдох сав газрын захиргаанаас саналыг авч, Засгийн газрын баталсан талбайгаас Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5.2, 17.5.3, 17.6-д заасан шаардлагад нийцүүлж, сонгон шалгаруулалтын талбайг ялгах болон давхцлыг шалгаж Үндэсний геологийн албанд хүргүүлнэ."

2/2.4 дэх хэсэгт:

"2.4. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь журмын 2.3-т заасан талбайгаас Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр зарлана."

2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал), Үндэсний геологийн алба (О.Чулуун), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Геологийн бодлогын газар (Б.Уянга)-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батбаярт үүрэг болгосугай.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ